

Үндэсний аудитын газар

Аудитын код: САГ-2017/294/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас:

Тэргүүлэх аудитор: С.Энхзаяа

Утас: 261663, 99117973 Цахим хаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Болд

Утас: 262071, 99017100 Цахим хаяг: boldch@audit.gov.mn

Аудитор: Б.Долгоржав Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn

Аудитор: Г.Жавхлан Цахим хаяг: javkhlанg@audit.gov.mn

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	10
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.12	Шилэн дансны мэдээлэл	10
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал	12
3.1	«management_zurchil1»	
3.2	«management_zurchil2»	
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	17
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	17
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	17
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17

1 Аудитын гэрчилгээ

 ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын IV байр, Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230, E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn	ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ДАРГА Б.НАРАНТУЯА ТАНАА
2017.02.16 № 3/99 танай _____-ны № _____-т	
Аудитын гэрчилгээ	
Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.	
Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл	
Эрүүл мэндийн хөгжлийн төв нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.	
Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.	
Санал дүгнэлтийн үндэслэл	
Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.	
Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.	
Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.	
\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\0216SAG8.Docx 070111	

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЭНХЗАЯА

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Аудитын тайланг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга Б.Нарантуяад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.01.25-наас 2017.02.25-ны хооронд хийж, аудитын тайланг 2017.02.25-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Б.Долгоржав, Г.Жавхлан нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017.01.23-нд төрийн аудитын байгууллагад 100–р албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрүүл мэндийн хөгжлийн төв Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.14.15-д "Тусгай мэргэжлийн төв нь улсын хэмжээнд үндсэн, эсхүл төрөлжсөн нэг мэргэшлээр лавлагаа тусламж, үйлчилгээг амбулатороор үзүүлж, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэх бөгөөд эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана" гэсэн эрхэм зорилгын дор Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж ирсэн байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төв дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ.

Эрүүл мэндийн хөгжлийн төв "Эрүүл мэндийн хөгжлийн төв нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт зохион байгуулах, мэргэжлийн зэрэг олгох, эрүүл мэндийн тогтолцооны судалгаа хийх, эмийн бүртгэл, экспорт, импортын лиценз олгох " зэрэг үндсэн чиг үүрэгтэй байгууллага юм.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд тайлант хугацаанд томоохон шинэчлэлт өөрчлөлт ороогүй байна.

2.5 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аудитын төлөвлөлтийн явцад Эрүүл мэндийн хөгжлийн төвийн санхүүгийн дотоод хяналтын тогтолцоог сайн гэж үнэлсэн ба гүйцэтгэл, тайлагналын үед дахин хянахад хэвийн байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд Сайн буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Эрүүл мэндийн хөгжлийн төв санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд Нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS” програм хангамж ашиглажээ.

Тус програм нь Эрүүл мэндийн хөгжлийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг ба Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 1 асуудал эрсдэл өндөр, 3 асуудал эрсдэл дунд гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 12 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 1 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих, шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт зардлаас тооцох нь зохимжтой гэж үзэв.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3.8 тэрбум төгрөг бөгөөд түүний 2 хувь 77.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт зардлын 2 хувиар тооцох нь зохимжтой гэж үзэв.

Гүйцэтгэлийн үе шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн материаллаг байдал илэрсэнгүй.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 4 чиглэлээр 4 эрсдэлтэй асуудалд 4 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 100 хувь буюу 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	4	392.7	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
Дүн		4	392.7	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав. Үүнд:

1. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хүчингүй болсон Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолын дагуу үндсэн хөрөнгийг элэгдэл хорогдлыг тооцохоор байна.

Шийдвэрлэсэн:

Менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх

2. Төрийн сангийн зардлаар сурсан болон сурч байгаа эмч нарын гэрээг дүгнэх дотоод хяналтын тогтолцоо сул байгаа нь Монгол Улсын Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын 2015 оны 97/56 дугаар тушаалаар баталсан “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын зардлыг

улсын төсвөөс санхүүжүүлэх журам”-ын 6.1-д “Суралцагч нь төгсөлтийн дараах мэргэшлийн сургалтанд захиалгаар суралцаж төгссөний дараа тухайн гэрээ байгуулсан байгууллагад 5 ба түүнээс доошгүй жил, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан бол 3 ба түүнээс доошгүй жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллана. Хэрэв суралцагч тухайн ажиллах гэрээг биелүүлээгүй тохиолдолд сургалтын төлбөр, тэтгэлэг зэрэг суралцагчтай холбоотой гарсан нийт зардлыг гэрээний дагуу нөхөн төлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн:

Менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх

3. Эмч нарыг төрөлжсөн мэргэжлийн сургалтад хамруулах зардал элсэгч байхгүйгээс шалтгаалан 103.3 сая төгрөгийг зарцуулалгүй улсын төсөв рүү татуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн:

Менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх

4. Хичээл үйлдвэрлэлийн дадлагын 289.7 сая төгрөгийн зардлаас эмнэлгүүдэд олгож буй сургалтын зардлыг Эрүүл мэндийн хөгжлийн төвд цаг тухай бүрд нь эргэн тайлагнахгүй байгаа нь Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 491/А/472 дугаар тушаалаар баталсан “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”-ын 11.2.9-д “Сургалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг гаргаж, жил бүрийн 06 дугаар сарын 25-ны дотор ажлын албанд ирүүлж, тайлангуудыг Ажлын алба нэгтгэн Зөвлөлд дараа оны 01 дүгээр сарын 20-ны дотор танилцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн:

Менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөгдөөгүй болно.

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй болно.

2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал байхгүй болно.

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

2.11 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Эрүүл мэндийн хөгжлийн төв өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 3,409,136,400.0, хөрөнгийн зардалд 0 төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	3,409,136,400.00	3,418,661,084.9	0.27%	9,524,684.9
1.1	Урсгал зардал	3,409,136,400.00	3,418,661,084.9	0.27%	9,524,684.9

Төсөвт зардлын гүйцэтгэл 0.27 хувь байгаа нь батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж батлагдсан төсвийг 9.5 сая төгрөгөөр хэмнэж ажилласантай холбоотой байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төв тайлант онд 180.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 390.0 сая төгрөг зарцуулсан байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Эрүүл мэндийн хөгжлийн төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад эрсдэлтэй асуудал тогтоогдсонгүй.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх аудитаар Эрүүл мэндийн хөгжлийн төвийн санхүүгийн тайланд бие даасан аудитын дүгнэлт гаргаагүй бөгөөд Үндэсний аудитын газраас Эрүүл мэндийн сайдын 2015 оны төсвийн багцад хийсэн аудитын түүвэрт хамрагдсан байна.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Эрүүл мэндийн хөгжлийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

3.1 НББ-ийн бодлогын баримт бичиг

Илрүүлэлт

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хүчингүй болсон Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолын дагуу үндсэн хөрөнгийг элэгдэл хорогдлыг тооцохоор байна.

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт стандарт, хууль эрх зүйн холбогдох өөрчлөлтүүдийг цаг тухай бүрд нь хийж байх

Хариуцах ажилтан

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга
Б.Нарантуяа, нягтлан бодогч Д.Гантуяа

Эрсдэл

Бүртгэл тайлан буруу илэрхийлэгдэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн материаллаг бус зөрчлийг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

3.2 Дотоод хяналтын тогтолцоо

Илрүүлэлт

Төрийн сангийн зардлаар сурсан болон сурч байгаа эмч нарын гэрээг дүгнэх дотоод хяналтын тогтолцоо сул байгаа нь Монгол Улсын Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын 2015 оны 97/56 дугаар тушаалаар баталсан “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх журам”-ын 6.1-д “Суралцагч нь төгсөлтийн дараах мэргэшлийн сургалтанд захиалгаар суралцаж төгссөний дараа тухайн гэрээ байгуулсан байгууллагад 5 ба түүнээс доошгүй жил, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан бол 3 ба түүнээс доошгүй жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллана. Хэрэв суралцагч тухайн ажиллах гэрээг биелүүлээгүй тохиолдолд сургалтын төлбөр, тэтгэлэг зэрэг суралцагчтай холбоотой гарсан нийт зардлыг гэрээний дагуу нөхөн төлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж

Дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, гэрээний дүгнэлтийг хангуулж хэвших

Хариуцах ажилтан

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга
Б.Нарантуяа, нягтлан бодогч Д.Гантуяа

Эрсдэл

Төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр нөлөө буурах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн материаллаг бус зөрчлийг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

3.3 Зардал

Илрүүлэлт

Эмч нарыг төрөлжсөн мэргэжлийн сургалтад хамруулах зардал элсэгч байхгүйгээс шалтгаалан 103.3 сая төгрөгийг зарцуулалгүй улсын төсөв рүү татуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Хариуцах ажилтан

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга
Б.Нарантуяа, нягтлан бодогч Д.Гантуяа

Эрсдэл

Батлагдсан төсвийн үр дүн гарахгүй байх

Зөвлөмж

Холбогдох дээд шатны байгууллагад асуудлыг танилцуулж, батлагдсан төсвийн хүрээнд төрөлжсөн мэргэжлийн сургалтад эмч нарыг хамруулах ажлыг зохион байгуулах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн материаллаг бус зөрчлийг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

3.4 Зардал

Илрүүлэлт

Хичээл үйлдвэрлэлийн дадлагын 289.7 сая төгрөгийн зардлаас эмнэлгүүдэд олгож буй сургалтын зардлыг Эрүүл мэндийн хөгжлийн төвд цаг тухай бүрд нь эргэн тайлагнахгүй байгаа нь Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 491/А/472 дугаар тушаалаар баталсан “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”-ын 11.2.9-д “Сургалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг гаргаж, жил бүрийн 06 дугаар сарын 25-ны дотор ажлын албанд ирүүлж, тайлангуудыг Ажлын алба нэгтгэн Зөвлөлд дараа оны 01 дүгээр сарын 20-ны дотор танилцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Хариуцах ажилтан

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга
Б.Нарантуяа, нягтлан бодогч Д.Гантуяа

Эрсдэл

Төсвийг зориулалтын дагуу зарцуулахгүй байх, сургалтын зардал үр дүнгүй байх

Зөвлөмж

Эмнэлгүүдэд олгож буй сургалтын зардлын тайланг журмын дагуу цаг тухай бүрд нь нэгтгэж танилцуулж байх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн материаллаг бус зөрчлийг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

4.3 Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

4.4 Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

СТ-1А

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>154776034.97</u>	<u>137730155.60</u>
33	АВЛАГА	0.37	6056237.40
335	Бусад авлага	0.37	6056237.40
3351	Байгууллагаас авах авлага	0.37	6056237.40
35	БАРАА МАТЕРИАЛ	154776034.60	131673918.20
351	Түүхий эд материал	36964822.00	27755022.00
35110	Тусгай зориулалттай материал	17554850.00	8345050.00
35130	Эм боох материал	19409972.00	19409972.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	105531856.00	85520272.00
354	Хангамжийн материал	12279356.60	18398624.20
35410	Бичиг хэргийн материал	3545370.00	2859537.60
35430	Сэлбэг хэрэгсэл	645211.88	1290211.88
35440	Түлш, шатах тослох материал	6086000.00	11560600.00
35450	Барилгын засварын материал	2002774.72	2688274.72
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2010939441.12</u>	<u>1944426308.85</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2010939441.12	1944426308.85
392	Биет хөрөнгө	1948005287.04	1890042899.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	3349023883.00	3594996551.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2347303576.36	-2425098965.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	160265094.33	160265094.33
39204	Хуримтлагдсан элэгдэл	-108736166.11	-119732185.79
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1267836023.49	1285771643.49
39206	Хуримтлагдсан элэгдэл	-487805029.00	-709860675.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	258638859.00	263385359.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-147563934.64	-167359811.45
39214	Бусад үндсэн хөрөнгө	3712000.00	3712000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-61866.67	-804266.71
39217	Ном		4768156.00
393	Биет бус хөрөнгө	62934154.08	54383409.39
39301	Програм хангамж	59177093.55	59177093.55
39302	Хуримтлагдсан элэгдэл	-28538439.47	-37089184.16
39303	Бусад биет бус хөрөнгө	32295500.00	32295500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2165715476.09</u>	<u>2082156464.45</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>0.00</u>	<u>0.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2165715476.09</u>	<u>2082156464.45</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2165715476.09	2082156464.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2390485153.08	2390485153.08
51101	Өмч: - төрийн	2390485153.08	2390485153.08

512	Хуримтлагдсан үр дүн	-224769676.99	-308328688.63
51210	Өмнөх үеийн үр дүн	-224769676.99	-224769676.99
51220	Тайлант үеийн үр дүн		-83559011.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2165715476.09</u>	<u>2082156464.45</u>

СТ-2А

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4170749789.50	3805678394.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	369783800.01	461857261.90
120	Нийтлэг татварын бус орлого	369783800.01	461857261.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	369783800.01	461857261.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	256230061.41	350210261.90
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	102590518.00	111647000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10963220.60	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3800965989.49	3343821133.09
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3097067817.90	2953236400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3094923370.00	2953236400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2144447.90	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	703898171.59	390584733.09
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	29061620.00	4768156.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	119427361.66	136276486.09
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	220192215.81	245972668.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	307847169.00	3567423.00
131106	Төсвийн урамшуулал	27369805.12	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4333048394.48	3889237406.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4333048394.48	3889237406.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4111544261.54	3649334590.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	706557925.59	814881311.61
210101	Үндсэн цалин	613047025.59	713054411.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	93510900.00	101826900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77110697.29	86253071.91
210201	Тэтгэврийн даатгал	77110697.29	86253071.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68384646.00	77246819.52
210301	Гэрэл, цахилгаан	33516591.00	36295185.52
210302	Түлш, халаалт	20647257.00	25522396.00
210303	Цэвэр, бохир ус	14220798.00	15429238.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59130165.81	73753350.98
210401	Бичиг хэрэг	25169335.60	18177565.40
210402	Тээвэр, шатахуун	24538625.00	7848500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4661859.21	7053916.58
210404	Ном, хэвлэл	8000.00	

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2370000.00	3632280.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2382346.00	4445725.00
210408	Бараа материал акталсны зардал		32595364.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	228572273.00	22169488.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	125580400.00	802800.00
210604	Урсгал засвар	102991873.00	21366688.00
2107	Томилолт, зочны зардал	30562695.00	14365066.00
210702	Дотоод албан томилолт	30562695.00	14365066.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	163627090.00	270501967.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	138118480.00	210996167.04
210803	Даатгалын үйлчилгээ		508410.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	278800.00	423500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	38500.00	67000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6841300.00	8199100.00
210807	Газрын төлбөр	412460.00	423540.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	17937550.00	49884250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2777598768.85	2290163515.52
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2483349103.16	1950227439.25
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	294249665.69	339936076.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	221504132.94	239902816.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	112566600.00	59127000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	53156400.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40312600.00	59127000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19097600.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	108937532.94	180775816.05
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	108937532.94	180775816.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-162298604.98	-83559011.64
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-162298604.98	-83559011.64

СТ-2А

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3782807885.19	3554937570.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	358820579.41	461857261.90
120	Нийтлэг татварын бус орлого	358820579.41	461857261.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	358820579.41	461857261.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	254370061.41	350090261.90
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	104450518.00	111767000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3423987305.78	3093080309.09
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3094923370.00	2953236400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3094923370.00	2953236400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	329063935.78	139843909.09
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	119427361.66	136276486.09
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	182266769.00	3567423.00
131106	Төсвийн урамшуулал	27369805.12	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3819951049.19	3532255450.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3819951049.19	3532255450.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3598446916.25	3286296397.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	706557925.59	814881311.61
210101	Үндсэн цалин	613047025.59	713054411.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	93510900.00	101826900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77110697.29	86253071.91
210201	Тэтгэврийн даатгал	77110697.29	86253071.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68384646.00	77246819.52
210301	Гэрэл, цахилгаан	33516591.00	36295185.52
210302	Түлш, халаалт	20647257.00	25522396.00
210303	Цэвэр, бохир ус	14220798.00	15429238.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45406974.21	44827996.58
210401	Бичиг хэрэг	14292690.00	16227900.00
210402	Тээвэр, шатахуун	21342125.00	12971600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4690859.21	7053916.58
210404	Ном, хэвлэл	428000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2370000.00	3632280.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2283300.00	4942300.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	230641673.00	23547876.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	125580400.00	1947593.00
210604	Урсгал засвар	105061273.00	21600283.00
2107	Томилолт, зочны зардал	30562695.00	14365066.00
210702	Дотоод албан томилолт	30562695.00	14365066.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	176778890.00	257973017.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	141938530.00	222138167.04
210803	Даатгалын үйлчилгээ		508410.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	278800.00	423500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	38500.00	67000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7349300.00	10124500.00
210807	Газрын төлбөр	412460.00	423540.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	26761300.00	24287900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2263003415.16	1967201239.25
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2263003415.16	1967201239.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	221504132.94	245959053.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	112566600.00	59127000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	53156400.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40312600.00	59127000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19097600.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	108937532.94	186832053.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	108937532.94	186832053.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-37143164.00	22682120.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	12513220.00	22682120.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12513220.00	22682120.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12513220.00	22682120.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12513220.00	22682120.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-12513220.00	-22682120.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-49656384.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	49656384.00	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл					0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,390,485,153.08		-224,769,676.99		2,165,715,476.09
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,390,485,153.08	0.00	-224,769,676.99	0.00	2,165,715,476.09
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,390,485,153.08	0.00	-224,769,676.99	0.00	2,165,715,476.09
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,390,485,153.08	0.00	-224,769,676.99	0.00	2,165,715,476.09
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,390,485,153.08	0.00	-224,769,676.99	0.00	2,165,715,476.09
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-83,559,011.64		-83,559,011.64
D09	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,390,485,153.08	0.00	-308,328,688.63	0.00	2,082,156,464.45

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3409136400.00	3418661084.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3409136400.00	3418661084.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3350009400.00	3178758268.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	768372100.00	750261368.71
210101	Үндсэн цалин	666545200.00	648434468.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	101826900.00	101826900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80230800.00	80230800.00
210201	Тэтгэврийн даатгал	51056000.00	51056000.00
210202	Тэтгэмжийн даатгал	5835000.00	5835000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7293700.00	7293700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1458700.00	1458700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14587400.00	14587400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84865300.00	77246819.52
210301	Гэрэл, цахилгаан	40000000.00	36295185.52
210302	Түлш, халаалт	25577800.00	25522396.00
210303	Цэвэр, бохир ус	19287500.00	15429238.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45815200.00	44100696.58
210401	Бичиг хэрэг	15546400.00	15420700.00
210402	Тээвэр, шатахуун	13620000.00	12971600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7985400.00	7053916.58
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3641200.00	3632280.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5022200.00	5022200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49552700.00	46150096.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25000000.00	24549813.00
210604	Урсгал засвар	24552700.00	21600283.00
2107	Томилолт, зочны зардал	9119100.00	9098086.00
210702	Дотоод албан томилолт	9119100.00	9098086.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	286754200.00	257973017.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	238748000.00	222138167.04
210803	Даатгалын үйлчилгээ	770000.00	508410.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	880000.00	423500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	187000.00	67000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12419200.00	10124500.00
210807	Газрын төлбөр	750000.00	423540.00

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	33000000.00	24287900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2025300000.00	1913697385.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2025300000.00	1913697385.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59127000.00	239902816.05
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	180775816.05
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		180775816.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	59127000.00	59127000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	59127000.00	59127000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3409136400.00	3418661084.90
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2963136400.00	2953236400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2963136400.00	2953236400.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	446000000.00	465424684.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	346000000.00	353657684.90
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100000000.00	111767000.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	73.00	75.00
620001	Удирдах ажилтан	2.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	59.00	62.00
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00